



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

IV.ХЭЛЭЛЦСЭН НЬ:


Дорнговь аймгийн Замын-Үүд дулааны станц, станцын ус, дулаан хангамж, ариутгах татуургын байгууламж, түүний инженерийн шугам сүлжээний ашиглалтын үйл ажиллагааг хариуцах чиг үүрэг бүхий төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай асуудлаар санал боловсруулж, танилцуулах тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн А/243 дугаар тушаалаар батлагдсан Ажлын хэсгээс гарсан саналын дагуу Дорнговь аймгийн Замын-Үүд сум болон Замын-Үүдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ашиглалтанд орсон Дулааны станц, түүний инженерийн барилга байгууламжийг Замын-Үүд сум, Замын-Үүдийн чөлөөт бүсийн хэрэглэгчдийг 2 дугаар хэлхээний инженерийн шугам сүлжээнд холбох хүртэлх хугацаанд Барилга хот, байгуулалтын яамны харьяа Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргааг өргөтгөн дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий “Замын-Үүдийн дулааны станц, дулааны шугам сүлжээний ашиглалтын өмнөх захиргаа” төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулах нь зүйтэй гэж үзэв.

“Замын-Үүдийн дулааны станц, дулааны шугам сүлжээний ашиглалтын өмнөх захиргаа” төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулах тухай саналаа Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэхийг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгав”... гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



000067

D:\Huraldaanii material\2019 on\2019.10.10 №20.docx